



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТР



ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ ТӨВИЙН ДҮРЭМ

2024 оны 08 дугаар сарын 12-ны
өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлнэ.

Удирдах зөвлөлийн
2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 24/13 тоот
тогтоолын хавсралтаар батлав.

**МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТРЫН
ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ ТӨВИЙН ДҮРЭМ**

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Эвлэрүүлэн зуучлах төв (цаашид Төв гэх) нь Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын холбооны дэргэдэх нэгж мөн болно.
- 1.2 Эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа нь “Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль”, энэхүү дүрмийн хүрээнд спорттой холбоотойгоор үүссэн аливаа хэрэг, маргааныг эвийн журмаар, харилцан буулт хийх, зөвшилцөх, нэг тохиролцоонд хүргэх аргачлалаар шийдвэрлэж дуусгахыг эрхэм зорилгоо болгоно.
- 1.3 Энэхүү дүрмийн 1.2-т заасан маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэх эрх гагцхүү Эвлэрүүлэн зуучлагчид хадгалагдана.
- 1.4 Төв нь үйл ажиллагаандaa Монгол улсын Үндсэн хууль, Эвлэрүүлэн зуучлалын тухай Монгол улсын хууль болон бусад хууль, тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

Хоёрдугаар бүлэг. Төвийн зорилго, зарчим, бүрэн эрх

- 2.1 Төв нь спорттой холбоотойгоор иргэд, байгууллага хооронд үүссэн аливаа хэрэг, маргааныг эвийн журмаар, харилцан буулт хийх, зөвшилцөх, нэг тохиролцоонд хүргэх аргачлалаар шийдвэрлэж дуусгахыг эрхэм зорилгоо болгоно.
- 2.2 Төв нь үйл ажиллагаандaa Эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн 5.2-т заасан зарчмаас гадна хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэх, шударга ёсыг сахих, нээлттэй, ил тод, ёс зүйтэй байх зарчмыг баримталж ажиллана.
- 2.3 Төв нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
 - 2.3.1 Спорттой холбоотой маргааны талуудыг эвлэрүүлэн зуучлах ажлыг зохион байгуулна.
 - 2.3.2 Эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан сургах ажлыг зохион байгуулна.
 - 2.3.3 Эвлэрүүлэн зуучлагчийг бүртгэх, олон нийтэд нээлттэй зарлах ажлыг зохион байгуулна.
 - 2.3.4 Төрийн болон төрийн бус байгууллага, төсөл, хөтөлбөр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлтэй өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамтран ажиллана.
 - 2.3.5 Эвлэрүүлэн зуучлах чиглэлээр хууль, тогтоомж, бодлогын бичиг баримт болон дүрэм, журмын төсөлд санал зөвлөмж өгөх, байр сууриа илэрхийлэх.
 - 2.3.6 Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, тамирчид, шүүгчид, холбооны удирдлагын болон гүйцэтгэх багийн ажилчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр мэдээлэл хийх, сургалт зохион байгуулах, бусад байгууллага, иргэнтэй хамтран ажиллах
 - 2.3.7 Олон улсын Эвлэрүүлэн зуучлалын байгууллагуудтай ажил хэрэгч холбоо тогтоон хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
 - 2.3.8 Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын холбоо болон төрийн үйл ажиллагаатай харшлахгүй бусад үйл ажиллагаа явуулах

Гуравдугаар бүлэг Эвлэрүүлэн зуучлах төвийн
удирдлага, зохион байгуулалт

- 3.1 Төвийн удирдах дээд байгууллага нь Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын холбооны Удирдах зөвлөл (цаашид Удирдах зөвлөл гэх) байна.
- 3.2 Спортын маргааныг эвлэрүүлэн зуучлах төвийн гишүүдийн тоо гурав байна. Тус зөвлөлийн гишүүдийг Удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар 4 жилийн хугацаагаар сонгоно.
- 3.3 Зуучлагчид тавигдах шаардлагын нэмэлт шаардлага нь спортын арбитрч болох чиг хандлагад чиглэгдсэн зорилготой байна.
- 3.4 Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
 - 3.4.1 Төвийг үүсгэн байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах
 - 3.4.2 Эвлэрүүлэн зуучлах төвийн даргыг томилох
 - 3.4.3 Төвийн дүрмийг батлах, дурэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох
 - 3.4.4 Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам, Эвлэрүүлэн зуучлагчийн зардал, хураамж, ажлын хөлс, урамшууллын журмыг батлах
 - 3.4.5 Эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтыг батлах
- 3.5 Төвийн дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
 - 3.5.1 Төвийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах
 - 3.5.2 Төвийг гадаад, дотоодод төлөөлөх
 - 3.5.3 Удирдах зөвлөлийн хуралд эрхлэх хүрээний асуудлыг хэлэлцүүлэх
 - 3.5.4 Бүрэн эрхийн хүрээнд тушаал, шийдвэр гаргах
 - 3.5.5 Эвлэрүүлэн зуучлагчид гаргах өргөдөл, эвлэрлийн гэрээ, мэдэгдэх хуудасны загварыг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих
 - 3.5.6 Төвийн ажлын албаны дарга, ажилтанг томилох, чөлөөлөх
 - 3.5.7 Удирдах зөвлөлд хоёр жилд 1 удаа ажлаа тайлагнах
 - 3.5.8 Эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих
 - 3.5.9 Эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтыг батлах
 - 3.5.10 Эвлэрүүлэн зуучлагчийн эрхийг түдгэлзүүлэх, хасах, гэрчилгээг хүчингүй болгох, нэрсийн жагсаалтаас хасах
- 3.6 Төвийн Ажлын албаны дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
 - 3.6.1 Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах
 - 3.6.2 Төвд ажиллах ажилтныг сонгон шалгаруулж Төвийн даргад танилцуулах
 - 3.6.3 Төвийн даргын эзгүйд түр орлох
 - 3.6.4 Төвийг төлөөлөн гадаад, дотоодын иргэд, байгууллага, хуулийн этгээдтэй харилцах
 - 3.6.5 Ажлаа сард 1 удаа төвийн даргад тайлагнах
 - 3.6.6 Төвийн эвлэрлүүлэн зуучлагч, захиргааны ажилтнуудаас үйл ажиллагааны тайлан авах, үнэлгээ өгөх
 - 3.6.7 Эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах эрхийг сунгах, чөлөөлөх асуудлыг шийдвэрлүүлэхээр төвийн даргад санал гаргах
 - 3.6.8 Төвийн бүтэц, орон тоо, үйл ажиллагааны талаарх саналаа төвийн даргад хүргүүлэх

Дөрөвдүгээр бүлэг. Эвлэрүүлэн зуучлагч болох эрх, шалгуур

- 4.1 Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8.2-т зааснаар төвийн Ажлын албаны дарга нь зуучлагчийн эрхтэй, дараах шаардлага хангасан эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулж зуучлагчийг сонгон шалгаруулж Ерөнхийлөгчид танилцуулж зуучлагчдын нэrsийн жагсаалтад бүртгэнэ.
 - 4.1.1 30-аас дээш насны ял шийтгэлгүй
 - 4.1.2 Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан
 - 4.1.3 Эвлэрүүлэн зуучлах сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан
 - 4.1.4 Харилцааны ур чадвар, итгэл даасан байх
 - 4.1.5 Эвлэрүүлэн зуучлалыг сурталчлах, олон нийтэд танилцуулах ажилд оролцох хүсэлт сонирхолтой
- 4.2 Дараах нөхцөлд эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах эрх үүрэг дуусгавар болно.
 - 4.2.1 Зуучлагч өөрөө татгалзах хүсэлт гаргасан Нас барсан эсхүл эрх зүйн чадамжгүй болсон
 - 4.2.2 Хууль тогтоомж, ёс зүйн дүрэм болон бусад холбогдох дүрэм журам зөрчсөн
 - 4.2.3 Хууль тогтоомжид заасан бусад шалтгаан
- 4.3 Эвлэрүүлэн зуучлалын гэрээг Монголын Олон улсын ба Үндэсний Спортын арбитраар баталгаажуулсан байна. Энэ нь шүүхэд хандаж захирамж, гүйцэтгэх хуудас бичүүлэх үндэслэл болно.

Тавдугаар бүлэг. Төвийн эд хөрөнгө, санхүүжилт

- 5.1 Төвийн эд хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө, тэдгээртэй адилтгах бусад активаас бүрдэнэ.
- 5.2 Төв нь ашиг олох зорилгоор аж ажуйн үйлчилгээ явуулахгүй боловч хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлж өөрийгөө санхүүжүүлж болно.
- 5.3 Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.
 - 5.3.1. Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын холбоо болон Спортын арбитраас шилжүүлж өгсөн эд хөрөнгө
 - 5.3.2. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамж
 - 5.3.3. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зориулсан хөрөнгө
 - 5.3.4. Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн бэлэг, хандив, тусламж

Зургаадугаар бүлэг. Нууц хадгалах

- 6.1 Төвийн нарийн бичгийн дарга болон эвлэрүүлэн зуучлагчид нь эвлэрүүлэн зуучлалын
- 6.2 ажиллагааны замаар олж мэдсэн иргэн, байгууллагын нууцыг хадгалах үүрэгтэй.

Долдугаар бүлэг. Бусад

- 7.1 Төв нь насанд хүрээгүй болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, төлбөрийн чадваргүй иргэнд хөнгөлөлттэй нөхцөлөөр үйлчилж болно.
- 7.2 Энэхүү дүрэм нь Удирдах зөвлөлийн хурлаар батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр болно.